



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

МОНГОЛ УЛСЫН МАКРО - ЭДИЙН ЗАСГИЙН АНАЛИЗ

Доктор, Профессор Д.Бямбасүрэн

DDC
336.014
O-454

**МОНГОЛ УЛСЫН
МАКРО - ЭДИЙН ЗАСГИЙН АНАЛИЗ**

© Нээлттэй Нийгэм Форум

Энэхүү судалгааны тайланг хувийн хэрэгцээнээс бусад зорилгоор хэсэгчлэн болон бүтнээр нь хувилж олшруулахыг хүсвэл доорхи хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян гүний гудамж -5/1
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

Энэхүү судалгаагаар гаргасан үнэлэлт, дүгнэлт нь Нээлттэй Нийгэм Форумын байр суурийг илэрхийлэхгүй ба уг судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачийн үзэл бодлыг илэрхийлнэ.

ISBN 978-99929-831-0-8

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН МАКРО-ЭДИЙН ЗАСГИЙН СҮҮЛИЙН ГУРВАН ЖИЛИЙН ДИНАМИК.....	5
1. 2006 оны онцгой тохиол	5
2. 2009 оны хямралт дүр.....	6
3. 2006-2009 оны макро эдийн засгийн өөрчлөлтийн зам мөр	7
3.1. Хэрэглээний барааны үнийн ерөнхий индекс	7
3.2. Валютын ханш.....	10
3.3. Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж.....	12
3.4. Мөнгө, зээл	14
3.5. Гадаад худалдаа, үнэ	19
3.6. Үйлдвэрлэлийн зарим динамик.....	23
4. 2009 оны III улирлын төрх.....	24
5. Сүүлийн гурван жилийн замналын дүгнэлт, сургамж.....	27

“Монгол Улсын макро-эдийн засгийн сүүлийн гурван жил (2006 оны III улирал - 2009 оны III улирал)-ийн динамик” хэмээх энэхүү судалгааг Монголын Нээлттэй Нийгэм Форумын захиалгат “Монгол улсын макро-эдийн засгийн богино-дунд хугацааны компьютерийн загвар” боловсруулах сэдэвт ажлын хүрээнд загварын хувьсагчид, параметруудийн хамаарал, шүтэлцээг тодорхойлох судалгааны явцад боловсруулав.

Энэ судалгаанд зөвхөн үндэсний Статистикийн хорооноос сар бүр гаргадаг статистикийн товхимолуудын 2006 оны эхний хагасаас 2007 оны III улирал хүртэлх бүх дугаарыг ашиглав.

МОНГОЛ УЛСЫН МАКРО-ЭДИЙН ЗАСГИЙН СҮҮЛИЙН ГУРВАН ЖИЛИЙН ДИНАМИК

1. 2006 ОНЫ ОНЦГОЙ ТОХИОЛ

Монгол Улсын эдийн засаг сүүлийн 50 жилийн түүхэндээ анх удаа 2006 онд макро түвшний үзүүлэлтүүдийн тэнцвэр, эерэг

динамикийг хангасан юм. Эдгээр онцлогийг хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1

Но	Үзүүлэлт	2006 он
NN	1	2
1	ДНБ-ний өсөлт (өмнөх оноос) %	+8.6
2	Инфляцийн түвшин %	+6.0
3	Гадаад худалдааны тэнцэл	
	- Сая ам.доллар	+57.2
	- Экспортод эзлэх хувь	+3.7
4	Улсын төсвийн зарлага ДНБ-д эзлэх хувь -%	36.5
5	Төсвийн тэнцэл	
	- Сая төг	+6.3
	- Орлогод эзлэх хувь	+0.4
6	Нийт мөнгийг ДНБ-д харьцуулсан хувь	41.3
7	Валютын ханш (1 ам.дол = төг)-ийн өөрчлөлт - төг	-56.0
	өөрчлөлтийн хувь	-4.6
8	Банкны нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувийн жингийн өөрчлөлт - %	-0.76
9	Нийт мөнгөнд банкны зээлийн өрийн эзлэх хувь - %	79.6
10.	Банкны нөөцийг нийт зээлийн өрд харьцуулсан хувь - %	15.5
	Засгийн газрын нөөцийг хассанаар	6.3

Дээрх үзүүлэлтүүд 2006 оны нөхцөлд улс орны эдийн засаг нэн таатай тэнцвэрт хүрч ухаалаг

зохицуулалтын нөхцөлд тогтвортой динамикаа хадгалах чадвартай болсныг харуулж байна.

2. 2009 ОНЫ ХЯМРАЛТ ДҮР

2006 оноос хойш 3 жилийн дараа манай орны эдийн засгийн гол үзүүлэлтүүд эрс доройтож, эерэг тэнцвэр, динамикаа алджээ. Үүнийг 2009

оны эхний хагас жилийн байдлаар хүснэгт 2-оор үзүүлэв.

Хүснэгт 2

№	Үзүүлэлт	2009 оны эхний хагас жил
NN	1	2
1	ДНБ-ний өсөлт (өмнөх оны эхний хагас жилтэй харьцуулсан) %	-5.5
2	Инфляцийн түвшин %	+7.3%
3	Гадаад худалдааны тэнцэл	
	- Сая ам.доллар	-131.9
	- Экспортод эзлэх хувь	-17.3
4	Улсын төсвийн зарлага ДНБ-д эзлэх хувь -%	58.6
5	Улсын төсвийн тэнцэл	
	- Сая төг	-261.3
	- Орлогод эзлэх хувь	-31.6
6	Нийт мөнгийг ДНБ-д харьцуулсан хувь - %	39.2
7	Валютын ханш (1 ам.дол = төг)-ийн өөрчлөлт	
	төг	1435
	өөрчлөлтийн хувь	+24.0
8	Банкны нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх - %	11.6
9	Нийт мөнгөнд банкны зээлийн өрийн эзлэх хувь - %	105.5
10.	Банкны нөөцийг нийт зээлийн өрийн харьцуулсан хувь - %	18.2
11.	Засгийн газрын хадгаламж хассан банкны нөөцийг зээлийн өрд харьцуулсан - %	-2.9

Эдгээр үзүүлэлтүүд нь үндэсний эдийн засаг гол тэнцвэрээ алдаж, хурц хямралд өртсөнийг илэрхийлнэ.

3. 2006-2009 ОНЫ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ЗАМ МӨР

2008 оны сүүлийн хагасаас тодорхой илэрч 2009 оны эхний хагаст оргилдоо хүрсэн эдийн засгийн хямралт байдлыг Дэлхийн санхүү - эдийн засгийн хямралтай холбож тайлбарлах нь нийтлэг болжээ. Энэ нь Монголын эдийн засгийн байдал гадны үл давах нөлөөнөөс хамаарч байна гэсэн ойлголт төрүүлэхээс гадна, одоогийн хямралт байдал мөн л Дэлхийг хамарсан хямрал өнгөрөх явцад аяндаа шийдэгдэх мэт хүлээлт үүсгэж байна.

Энэ үзэл баримтлал хэр үндэслэлтэй болохыг зөвхөн бодит тоо материалд тулгуурласан судалгаа шинжилгээгээр нотлох буюу няцааж болно.

Үүний тулд эдийн засгийн гол индикаторууд хийгээд параметруудийн динамикийг улирал, хагас жилээр задалж үзэх шаардлагатай.

Үүнд:

3.1. Хэрэглээний барааны үнийн ерөнхий индекс

Хэрэглээний барааны үнийн хөдөлгөөн нь эдийн засгийн ерөнхий төлөв байдал, зах зээлийн тэнцвэрийн хамгийн мэдрэмтгий

индикатор билээ. 2006-2009 оны үнийн индексийг хүснэгт 3-д үзүүлэв.

Хүснэгт 3

Хугацаа (он, улиралаар)		2006 оны эцэстэй харьцуулсан индекс	Өмнөх улиралтай харьцуулсан индекс
	1	2	3
2007 он	I улирал	1.022	1.022
	II улирал	1.064	1.041
	III улирал	1.126	1.058
	IV улирал	1.151	1.022
2008 он	I улирал	1.247	1.083
	II улирал	1.376	1.104
	III улирал	1.434	1.041
	IV улирал	1.405	0.987
2009 он	I улирал	1.450	1.032
	II улирал	1.385	0.955

Үүнээс үзвэл:

1. Оны инфляцийн түвшинг нэг оронтой тоонд багтааж ирсэн зохицуулалт 2007 оны II – III улирлаас эхлэн алдагдаж, үнийн өсөлтийн темп 2008 оны III улиралд дээд цэгтээ хүрчээ.
2. Өнгөрсөн арван улирлын хугацаанд хэрэглээний үнийн хамгийн өндөр өсөлт 2008 оны 2-р улиралд тохиожээ.
3. Жил бүрийн эцсийн улиралд үнийн өсөлтийн хурд эрс буурах хандлага давтагдаж иржээ.

Үнийн өөрчлөлтийн ийм динамикийн учир шалтгаан нийтэд тодорхой бөгөөд 2007 оны II, III улиралд төсвийн цалин хөлсийг огцом нэмсний дараа үнийн өөрчлөлт гарч байсан бол 2008 оны II, III улиралд УИХ-ын сонгуульд намуудаас амалсан мөнгөний хүлээлт үнийн огцом өсөлтөд хүргэсэн билээ.

Хэрэглээний барааны үнийн ерөнхий өөрчлөлтийн хандлага, хурд нь янз бүрийн барааны бүлэг, төрлийн үнийн өөрчлөлтийн цомхотгосон илэрхийлэл байдаг. Ийм учраас үнийн өөрчлөлтийн явцыг барааны бүлгээр жиших нь ерөнхий индексийн учрыг тайлах нэг гол түлхүүр болно. Үүнийг хүснэгт 4-д үзүүлэв.

Хүснэгт 4

		Үүнээс							
Хэрэглээний сагсын үнийн индекс		Хүнс, ундаа	Хувцас, гутал	Орон сууц, ус, цахилгаан, дулаан	Эм тариа	Тээвэр	Боловсрол	Зочил буудал, нийтийн хоол	
1	2	3	4	5	6	7	8	9	
2006 он	1.000	1.000	1.000	1.000	1.000	1.000	1.000	1.000	
2007 он									
I улирал	1.022	1.010	99.8	0.999	1.000	0.988	1.000	1.035	
II улирал	1.064	1.039	100.1	1.002	1.004	1.022	1.000	1.046	
III улирал	1.126	1.186	102.5	1.056	1.115	1.062	1.202	1.126	
IV улирал	1.151	1.246	103.0	1.113	1.142	1.106	1.202	1.140	
2008 он									
I улирал	1.247	1.450	104.7	1.125	1.191	1.152	1.202	1.192	
II улирал	1.376	1.721	1.108	1.154	1.383	1.181	1.202	1.332	
III улирал	1.434	1.625	1.138	1.361	1.442	1.508	1.682	1.465	
IV улирал	1.405	1.545	1.200	1.367	1.450	1.391	1.682	1.498	
2009 он									
I улирал	1.450	1.649	1.219	1.329	1.483	1.361	1.682	1.529	
II улирал	1.385	1.587	1.204	1.376	1.453	1.393	1.682	1.507	

Хэрэглээний барааны үндсэн бүлгүүдийн дээрх бүтцээс үндэслэн дараах дүгнэлт хийж болох байна. Үүнд:

1. Хэрэглээний барааны үнийн өсөлтийн гол түүчээ нь хүнс, ундаа, нийтийн хоолны үнийн өсөлт болж байна.
2. Орон сууц, цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, боловсролын салбарын үйлчилгээний үнэ жил бүрийн 3-р улиралд огцом өсч нийт үнийн өсөлтөд түлхэц өгөөд жилийн эцэст үнийн өсөлт буурах мөчлөгт орох долгион үүсгэж байна.
3. Бараа, үйлчилгээний бараг бүх төрлийн үнийн эрчимтэй өсөлт жил бүрийн 2-3-р улиралд тохиож байгаа нь нийгмийн сэтгэл зүйн (баяр цэнгэл, амралт, сонгууль г.м) цаг уурыг дагасан амьдралын мөчлөгийг худалдаачид далимдуулдгийн нэг жишээ мөн.
4. Үнийн өсөлтийг нэг оронтой тоонд багтаан барьж байсан зохицуулалт 2007 оны 3-р улиралд бараа үйлчилгээний олонх төрөлд

алдагдаж улирлын эцэст 12.6%, оны эцэст 15.1%-ийн өсөлттэй гарсан нь эдийн засаг эрүүл бус болж эхэлсний баттай дохио юм.

5. 2008 онд бараа үйлчилгээний үнийн өсөлт огцом үсрэлтэд орж оны эцэст 2006 оныхоос 40.5% өссөн нь зах зээлийн тэнцвэр, баялгийн хуваарилалт, хэрэглээний бүтцийг хүчтэй өөрчилж, иргэдийн амьжиргааны түвшинд хүчтэй цохилт өгчээ. 2006-2009 оны үнийн өсөлтийг барааны бүлгээр дэсэлбэл:

• Боловсролын үйлчилгээ	68.2%
• Хүнс ундаа	58.7%
• Зочид буудал нийтийн хоол	50.7%
• Эм, тариа	39.3%
• Орон сууц, цахилгаан, дулаан	37.6%
• Гутал, хувцас	20.4%

болж байна.

3.2. Валютын ханш

Манай улс хэрэглээний барааны үлэмж хэсгийг импортоор хангадаг хийгээд хэрэглээний үнэ нь гадаад худалдааны үнэтэй салшгүй холбоотой. Үүнээс үндэслээд макро – эдийн засгийн зохицуулалтын нэн чухал хөшүүрэг нь

валютын курс болж байх шаардлага төрнө.

2006 оноос хойш өнгөрсөн 10 улиралд зах зээлийн тэнцвэрт гол нөлөөтэй хоёр валютын ханшийн өөрчлөлтийг хүснэгт 5-д үзүүлэв.

Хүснэгт 5

Хугацаа	Америк доллар		Юань	
	Ханш	Улирлын өөрчлөлт %	Ханш	Улирлын өөрчлөлт %
1	2	3	4	5
2006 оны эцэс	1165.00	-	149.10	-
2007 он				
I улирал	1165.00	0	150.80	+1.14
II улирал	1163.85	-0.10	150.80	0
III улирал	1184.26	+1.75	157.61	+4.50
IV улирал	1169.97	-1.21	160.18	+1.63
2008 он				
I улирал	1168.17	-0.02	166.58	+4.00
II улирал	1158.12	-0.86	168.78	+1.32
III улирал	1146.09	-1.04	167.43	-0.80
IV улирал	1267.51	+10.56	185.25	+10.64
2009 он				
I улирал	1524.07	+20.04	222.95	+20.35
II улирал	1435.49	-5.84	210.08	-5.77

Үүнээс үзвэл, доллар, юаньтай харьцах төгрөгийн ханш 2007 оны 3-р улиралд мэдэгдхүйц унаад, IV улирлаас эхлэн доллартай харьцах ханш сэргэж, 2008 оны IV улирал хүртэл 3.2% чангарчээ.

Харин юаньтай харьцах ханш тууштай унажээ. 2008 оны IV улирлаас эхлэн төгрөгийн ханш огцом унаж, 2009 оны I улиралд дээд цэгтээ хүрч 2006 онтой харьцуулбал:

- Доллар 31.6%
- Юань 50.0% чангарчээ.

2009 оны II улирлаас эхлэн одоог хүртэл дээрх валютын ханш үндсэндээ тогтвортой байгаа билээ. Доллар, юаньтай харьцах төгрөгийн ханшийн хөдөлгөөнийг хэрэглээний барааны

үнийн өөрчлөлттэй зэрэгцүүлбэл нэлээд сонирхолтой динамик ажиглагдаж байгааг хүснэгт 6-д үзүүлэв.

Хүснэгт 6

	2006 онтой харьцуулсан индекс			Үнийн өөрчлөлтөд харьцуулсан хувь	
	ХБ-ны үнэ	Долларын ханш	Юанийн ханш	Долларын ханш	Юаны ханш
1	2	3	4	5	6
2006 оны эцэс	1.000	1.000	1.000	1.000	1.000
2007 он					
I улирал	1.022	1.000	1.011	0.000	0.500
II улирал	1.064	0.999	1.011	-0.016	0.172
III улирал	1.126	1.018	1.057	0.143	0.452
IV улирал	1.151	1.004	1.074	0.026	0.490
2008 он					
I улирал	1.247	1.003	1.117	0.012	0.473
II улирал	1.376	0.994	1.132	-0.002	0.351
III улирал	1.434	0.984	1.122	-0.004	0.281
IV улирал	1.405	1.087	1.242	0.215	0.597
2009 он					
I улирал	1.450	1.308	1.495	0.684	1.100
II улирал	1.385	1.232	1.409	0.602	1.062

Эндээс дараах дүгнэлт хийж болох байна:

1. Төгрөгийн доллартай харьцах ханш 2008 оны IV улирал хүртэл дотоод инфляциас бүрэн ангид байж, зарим тохиолдолд эсрэг хөдөлгөөнд өртөж байсан нь Монголбанк макро – эдийн засгийн зохицуулалтын мэдрэмжгүй төдийгүй үндэснийхээ эрх ашгийг хамгаалах бодлого баримталж чадаагүйг харуулж байна.

2. Төгрөгийн юаньтай харьцах ханш инфляцитай хүчтэй эерэг корреляцтай явж иржээ. 2009 оны эхний хагаст юаньтай харьцах төгрөгийн ханш үнийн өсөлтийг давж унажээ. Энэ нь худалдаа арилжаа эрхлэгчдийн хувьд дотоод үнийг цаашид ч хөөрөгдөх сонирхол төрүүлэх болно. 2007, 2008 оны II улиралд юаний ханшийн чангаралт үнийн өсөлтөөс хоцрох хандлага ажиглагдсан нь дээрх хугацаанд ноолуурын

нийлүүлэлттэй холбоотой юанийн хүрэлцээ нэмэгддэгтэй холбоотой юм.

3. Доллар, юаний ханш 2008 оны IV улирлаас огцом өсчээ. Хэрэглээний үнэ өсч байхад долларын ханшийг зохиомлоор тогтоон барьж, 2006 оны эцэст 1019 сая долларт хүрч байсан валютын нөөцөө 2 дахин бууртал хүлээсний эцэст огцом цочрол үүсгэсэн нь мөнгөний бодлогын гажуудлын илрэл бөгөөд хямралын өмнө сөхрөхийн нэг үндэс болжээ.

4. Экспортын гол нэрийн бүтээгдэхүүнээ ам.доллараар борлуулдаг манай орны хувьд 2007-2008 онд долларын ханшийг хатуу тогтоосноор дотоод үйлдвэрлэлийн орлогыг 2007 онд 162 тэрбум төгрөг, 2008 онд 934 тэрбум төгрөгөөр бууруулж, төсвийн үлэмж орлогыг алджээ. Ингэснээр хямрал доройтлын нэг үндсийг тавьсан байна.

3.3. Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж

Өнгөрсөн 3 жилд улсын төсвийн цалин хөлс, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж огцом өсчээ (Хүснэгт 7).

Хүснэгт 7

2006 оны II улирал =100

Үзүүлэлт	2006 оны II улирал	2007 оны II улирал	2008 оны II улирал	2009 оны II улирал
1	2	3	4	5
1. Төсвийн цалин, хөлс	100.0	132.4	278.5	311.0
2. Нийгмийн даатгалын тэтгэвэр	100.0	148.5	228.3	232.2
3. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	100.0	211.3	257.9	270.6

Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн ийм үсрэнгүй өсөлт макро – эдийн засгийн үндсэн тэнцвэрүүд хийгээд мөнгөний ханш, үнийн өсөлтөд нөлөөлөхгүй байж чадахгүй юм. 2009 оны II улирлын байдлаар улсын хэмжээний

сарын дундаж цалин 309.2 мян.төг болж байна. Цалингийн түвшинг ажил мэргэжлийн заагаар авч үзвэл, цалингийн түвшин төрийн ажилтныг тэтгэхэд илүү чиглэжээ.

Хүснэгт 8

Улсын дундаж цалин = 1.00

	Эрэгтэйчүүд	Эмэгтэйчүүд
1 Хууль тогтоогч, албан хаагч	1.730	1.370
2 Мэргэжилтэн	1.334	1.157
3 ИТА	1.217	0.965
4 Бичиг хэргийн туслах ажилтан	0.971	0.792
5 Үйлчилгээний ажилтан	0.932	0.732
6 ХАА, загас, ан	0.938	0.780
7 Үйлдвэр, худалдааны ажилтан	0.944	0.733
8 Машин тоног төхөөрөмжийн оператор, угсрагч	1.122	0.925
9 Энгийн мэргэжилтэн	0.668	0.651

Сүүлийн 3 жилийн төсвийн цалингийн өсөлтийн 15% нь 2007 оны II-IV улиралд, 69% нь 2008 оны II-IV улиралд, 16% нь 2009 оны II улиралд ногдож байна. Нийгмийн даатгалын тэтгэврийн өсөлтийн бүтцийг авч үзвэл, 36.6% нь 2007 оны II улиралд, 60.5% нь 2008 онд, 2.9% нь 2009 онд ногдож байна. Энэ байдал төрийн бодлого инфляцийг хөөрөгдсөнийг шууд илэрхийлнэ.

Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт дотоодын үйлдвэрлэлийн өсөлтөөс үлэмж түрүүлж, үнийн өсөлтийг хөөрөгдөөд зогсоогүй, импортын ачааллыг нэмж, гадаад худалдааны тэнцлийг алдагдуулж, валютын нөөцийг хомсдуулахад нөлөөлжээ гэж үзэх үндэслэл хангалттай байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9

Үзүүлэлт	2009 оны II улирал	Төсвийн цалин хөлсний
	2006 оны II улирал	өсөлтөд харьцуулсан индекс
1	2	3
Төсвийн цалин, хөлс	3.11	1.000
1 Аж үйлдвэрийн үйлдвэрлэл (зэрэгцүүлэх үнээр)	2.002	0.61
2 Барилга угсралтын ажил (оны үнээр)	1.445	0.465
3 Бойжсон төл	1.367	0.439
4 Тариалсан талбай	1.796	0.577
5 Импорт	1.445	0.464

Статистикийн мэдээллээс үзвэл, 2006 оны эхний хагас жилд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт (оны үнээр) 889.7 тэрбум төгрөг болж байсан бол 2007 онд 27.2%, 2008 онд 28.7% өсч, 2009 оны эхний хагас жилд 23.8% буурчээ. Өмнөх 2 жилийн борлуулалтын орлогын өсөлт нь үнэт болон өнгөт металлын экспортын үнийн өсөлттэй

холбоотойг нийтээр мэдэх билээ. Энэ бүхэн нь өнгөрсөн гурван жилд төрөөс цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн талаар авсан арга хэмжээ нь материал баялгийн нөөцөөр баталгаажуу бөгөөд тэр чанараараа макро – эдийн засгийн хямралд нөлөөлжээ гэж үзэх үндэслэл болж байна.

3.4. Мөнгө, зээл

Өнгөрсөн гурван жилд манай эдийн засгийн динамикт тохиолдсон хямрал олон талаар мөнгөний нийлүүлэлт, түүний бүтцийн

бодлоготой холбоотой гэж үзэж болохоор байна. Үүнийг хүснэгт 10-т үзүүлэв.

Хүснэгт 10

	Нийт мөнгө M_2	M_1	Үүнээс	
			Банкнаас гадуурх мөнгө	Харилцахын үлдэгдэл
1. Тэрбум төг				
2006 он IV улирал	1536.5	331.9	185.1	146.7
2007 он II улирал	2016.1	502.2	262.4	239.8
IV улирал	2401.9	590.5	283.3	307.1
2008 он II улирал	2564.7	628.9	307.8	317.1
IV улирал	2270.0	647.3	328.7	318.6
2009 он II улирал	2424.6	534.3	283.8	250.5
2. 2006 он = 100%,	100.0	100.0	100.0	100.0
2007 он II улирал	136.1	151.2	141.6	163.7
IV улирал	156.3	178.2	152.9	2.102
2008 он II улирал	166.9	189.7	165.9	2.170
IV улирал	147.8	195.5	177.3	2.178
2007 он II улирал	157.8	161.3	152.9	1.710

Үүнээс үзвэл сүүлийн 3 жилд мөнгөний нийлүүлэлт огцом савалгаатай байгаа бөгөөд 2006 - 2009 оны мөнгөний өсөлтийн 63.3% нь 2007 оны II улиралд ногдож байгаагийн дотор М1-ийн өсөлтийн 83.5%, харилцахын үлдэгдлийн өсөлтийн 89.7% нь тухайн улиралд ногдож байна.

2008 оны 3-р улирлаас Төв банкны мөнгөний бодлого эрс өөрчлөгдөж 2009 оны II улирлын эцэст 2008 оны мөн үетэй харьцуулбал, нийт

мөнгө 5.5%, М1 – мөнгө 15.1%, БГмөнгө 8.1%, төгрөгийн харилцахын үлдэгдэл 21.1% буурчээ. Харин энэ хугацаанд бараг мөнгө (хугацаат хадгаламж + валютын хадгаламж) 2.5% буурч үндсэндээ хэвээр үлджээ.

Мөнгөний нийлүүлэлтийн ийм бодлого эдийн засгийн бодит хэрэгцээнээс нэлээд зөрүүтэй байгааг дараах тоо баримт харуулж байна (Хүснэгт 11).

Хүснэгт 11

(тэрбум төг)

	2006 он	2007 он	2008 он	2009 он
1	2	3	4	5
1 ДНБ оны үнээр	3714.9	4557.5	6130.3	7050*
2 Нийт мөнгө - M_2	1536.5	2401.9	2270	2424.6
3 Мөнгөний эргэлтийн тоо	2.42	1.90	2.70	2.91
4 Төсвийн цалингийн өсөлт 2006 он = 100	100.0	132.4	278.5	311.0
5 Банкнаас гадуурх мөнгөний өсөлт 2006 он = 100	100.0	152.9	177.3	152.9
6 БГМ-ний өсөлтийг төсвийн цалингийн өсөлтөд харьцуулсан хувь	1.000	1.155	0.638	0.492

* Зохиогчийн тооцоо

Үүнээс үзвэл, 2007 онд мөнгөний нийлүүлэлт ДНБ-ийн эргэлтээс хэт түрүүлж мөнгөний эргэлтийн хурдыг 21.5% бууруулаад 2008 оны эцсээс мөнгө хумих огцом бодлого явуулж эргэлтийн хэрэгцээг 42% нэмж эдийн засгаа гацаанд оруулжээ.

Түүнчлэн БГМ-ний нийлүүлэлт 2007 онд төсвийн цалингийн өсөлтөөс 15.5% түрүүлж байснаа 2008 онд (оны эцэст) 36.2% хоцорч, 2009 оны эхний хагаст 51.8% хоцорч байгаа нь ялангуяа хөдөөгийн иргэдийн орлого үлэмж буурч байгаагаар холбоотой боловч бүхэлдээ дефляцийн угтвар нөхцөл болж байна.

Манай нийт мөнгөний 2/3 нь бараг мөнгө байдаг. Сүүлийн 3 жилд бараг мөнгөний

динамик, худалдан авах чадварт нэлээд өөрчлөлт гарчээ (Хүснэгт 12).

Хүснэгт 12

	Бараг мөнгө (тб.т)	2006 он = 100	Ам долларын ханш (төг)	Бараг мөнгө сая (ам.дол)	2006 он = 100
1	2	3	4	5	6
2006 он	1204.6	100.0	1165	1033.4	100.0
2007 он II улирал	1513.9	125.6	1164	1299.8	125.7
IV улирал	1810.8	150.3	1170	1547.2	149.5
2008 он II улирал	1939.8	161.0	1158	1674.4	162.1
IV улирал	1622.7	134.7	1267	1280.1	123.9
2009 он II улирал	1890.3	156.9	1435	1317.1	127.5

2006 оны эцэст нийт валютын нөөц 1019 сая ам долларт хүрч байсан бол 2009 оны эхэнд 500 сая доллар болсон нь бараг мөнгө эдийн засгийн хэрэгцээг үйлчлэх чадварыг ихээхэн сулруулсныг өмнө өгүүлсэн билээ.

Өмнөх хүснэгт 12-оос үзвэл бараг мөнгөний үлдэгдлийн өсөлт ДНБ-ний динамикаас ихээхэн зөрүүтэй явж иржээ (Хүснэгт 13).

Хүснэгт 13

	ДНБ (оны үнээр Тб.т)	2006 он = 100	Бараг мөнгө (тб.т)	2006 он = 100
2006 он	3714	100.0	1204.9	100.0
2007 он II улирал	-	-	1513.9	125.7
IV улирал	4557	122.7	1810.8	150.3
2008 он II улирал	-	-	1939.8	161.5
IV улирал	6130	165.1	1622.7	134.7
2009 он II улирал	-	-	1890.4	157.5
IV улирал	7050*	189.8*	2000.0*	166.1

* Зохиогчийн тооцоо

Өнгөрсөн онуудыг авч үзвэл 2007 оны дунд үес бараг мөнгөний өсөлт ДНБ-ний эргэлтээс 2 дахин илүү хурдтай нэмэгдээд 2008 оны эцсээс бараг 2 дахин хоцрох болжээ. Энэ нь төрийн мөнгөний бодлого алсын хараагүй, тооцоо судалгаагүй байгаагийн илрэл юм.

Сүүлийн 3 жилийн банкны зээл, зээлийн хүүгийн бодлогын хүрээ хамгийн хүнд зам туулж ирлээ. Банкны зээлийн өрийн үлдэгдэл, бүтцийн динамикийг хүснэгт 14-д үзүүлэв.

Хүснэгт 14

1	Нийт зээлийн өрийн үлдэгдэл		Хугацаа хэтэрсэн зээл		Чанаргүй зээл	
	Тб.т	2006 он = 100	Тб.т	2006 он = 100	Тб.т	2006 он = 100
	2	3	4	5	6	7
2006 он	1223.3	100.0	33.3	100.0	60.0	100.0
2007 он II улирал	1600.2	130.8	44.7	134.2	61.9	103.2
IV улирал	2056.1	168.1	40.3	121.0	68.1	113.5
2008 он II улирал	2559.4	209.2	54.6	164.0	73.0	121.7
IV улирал	2635.6	215.4	93.3	280.2	188.7	314.5
2009 он II улирал	2558.9	209.2	152.1	456.8	298.0	496.7

Эндээс үзвэл дараах онцлогуудыг анхаарч болно. Үүнд:

1. Өнгөрсөн 3 жилд зээлийн өр жил дараалан ДНБ-ний өртөгийн өсөлтөөс давж иржээ. Тэгэхдээ 2007 оны эхнээс 2008 оны эхний хагасыг дуустал жил хагасын хугацаанд 2007 оны эхний үлдэгдлээс 2.1 дахин өсчээ. Энэ бол зээлийн бодлого хэтэрхий сул байсны гэрч юм.

Энэхүү зээлийн “донтол”-д Монгол Улсын Засгийн газраас 2007 – 2008 оныг “Их

бүтээн байгуулалтын жил” хэмээн зарлаж, гадаад дотоодын барилгын компаниудын сүлбээгээр орон сууцны үнийг хөөрөгдөн, барилгын материал, техникийн хүчин чадалгүй, мэргэжлийн ажилчидгүй хэр нь барилгын үйлдвэрлэлийг зохиомлоор тэлсэн нь гол шалтгаан болсныг нийтээр мэднэ.

2. Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хэмжээ тогтвортой өсч 2008 оны сүүлийн хагаст огцом үсэрчээ. Энэ нь урьд өмнө олгосон зээлийн чанар, үндэслэлтэй холбоотой асуудал юм. Ийм ирээдүйг олж хараагүй

банкууд зөвхөн 2008 оны IV улиралд харанга дэлдсэн нь дэндүү оройтсон хэрэг байлаа.

Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл буюу найдваргүй зээл 2009 оны эхний хагаст нийт зээлийн 17.5%-д хүрч одоо улам нэмсээр байна. 2009 оны эхний хагасын байдлаар нийт зээлийн өрийн 21.1%-ийг барилгын салбар эзэлж байгаа билээ.

Одоо (II улирал) найдваргүй зээл банкны нийт нөөцийн 96.6%-д хүрчээ. Энэ байдал манай эдийн засгийн хямрал өнгөрөөгүй төдийгүй харин ч улам хүчтэй цохилт ирэхийн дохио болж байна.

3. Эдийн засаг хүчтэй уналтад байгаагийн зэрэгцээ зээлийн өр буурахгүй, зээлийн чанар суларч байгаа одоогийн нөхцөлд

банкуудад байршуулсан засгийн газрын хадгаламж 540.7 тэрбум төг буюу бүх банкны пассивын 15.0%-д хүрч банкуудыг тэтгэх гол багана болж байна. Гэвч энэ механизм удаан үйлчилж чадахгүй. Төрийн зээлийн бодлого эдийн засгийн эргэлтийг дэмжиж, түүгээр дамжуулан банкуудыг эрүүлжүүлэхэд чиглэх цаг ирнэ.

4. Эдийн засгийн хямрал хамгийн хурц илэрсэн 2008 оны IV улиралд Монгол Банк бодлогын хүүгээ 52% нэмээд энэ оны 7 ба 9 сард хоёр удаа бууруулсан ч хүүгийн түвшин 2008 оны дунд үеийнхээс 21% өндөр хэвээр байна. Энэ бодлого нь зээлийн эргэлтийг түгжиж, эдийн засгийг боомилжээ. Үүнийг банкуудын сүүлийн 1 жилийн зээлийн хөдөлгөөнөөс харж болно (Хүснэгт 16).

Хүснэгт 16

(тб.т)

	Зээлийн өрийн үлдэгдэл		2009.VI
	2008.VI	2009.VI	2008. VI
Бүгд	2559.4	2558.9	0.997
Үүнээс: Голомт	419.1	435.8	1.033
Капитал	48.8	53.6	1.098
ХААН	588.5	562.9	0.956
ХХБ	453.3	416.0	0.918
Монгол шуудан	179.2	140.7	0.785
Хадгаламж	51.5	52.1	1.009
Тээвэр хөгжил	8.8	9.1	1.034

Хүснэгт 16 үргэлжлэл

Эрэл	9.5	8.7	0.915
Кредит	4.5	4.6	1.022
Улаанбаатар	122.4	125.9	1.028
Зоос	167.4	191.8	1.145
Анод	179.2	170.9	0.954
Капитрон	84.4	90.9	1.087
Хас	136.5	162.2	1.197
Чингис хаан	86.7	107.9	1.259

Банкны салбар ийнхүү зогсонги, хүндрэлтэй байдалд орсон нь цаашид алдагдал, эрсдэлийг улам гүнзгийрүүлнэ. 2008 онд УИХ-аас иргэдийн хадгаламжийг төрөөс баталгаажуулах шийдвэр гаргасан билээ. Энэ бол хадгаламжийн даатгал биш юм. Банкуудын дампуурал “Анод” банкны нэгэн адил нүүрлэвэл төр хадгаламжийн эрсдэлийг даах боломжгүй билээ.

5. Банкны нийт зээлийн өрийн 34.2%-ийг иргэдийн зээл эзэлж байна. Энэ нь

тэдний жилийн мөнгөн орлогын 27-30%-тай тэнцэнэ. Гэтэл банкууд иргэдийн хугацаагүй хадгаламжид 0.4-1%, хугацаат хадгаламжид 0.2-1.5%-ийн хүү өгдөг атлаа зээлийг 1-4%-ийн хүүтэй өгдөг ажээ.

Үүнээс үзвэл, банкууд одоогийн нөхцөлд бодит эдийн засгийг мөнгөний эргэлтээр үйлчлэхээс илүү иргэддээ мөнгө хүүлж оршин тогтнож байна.

3.5. Гадаад худалдаа, үнэ

Монгол орны эдийн засгийн одоогийн хямралт байдал нь Дэлхийн санхүү - эдийн засгийн хямралт байдлаас улбаатай бөгөөд зэс, алт, түүхий эдийн үнэ өсч тогтворжиход манайд хямрал өнгөрөх мэт ойлголт нийгэмд нэлээд өргөн байдаг.

2003-2009 оны гадаад худалдааны эргэлтийн тоо баримтаас үзвэл дээрх асуудалд болгоомжтой хандах шаардлагатай байна (Хүснэгт 17).

Хүснэгт 17

1	Эхний хагас жилийн гүйлгээ				2007 он	2008 он
	2006 он	2007 он	2008 он	2009 он		
1	2	3	4	5	6	7
1 Экспорт						
- сая.долл	611.6	836.2	1276.3	762.9	1889.0	2539.3
- 2006 он = 100	100.0	136.7	208.7	124.7	-	-
2. Импорт						
- сая.долл	617.2	868.4	1695.0	892.8	2117.3	3615.8
- 2006 он = 100	100.0	140.7	274.6	144.6	-	-
3. Гадаад худалдааны тэнцэл						
- сая ам.долл	-5.6	-31.8	-418.7	-129.9	-228.3	-1076.5
- 2006 он = 100	100.0	567.9	75 дахин	23 дахин	-	-
Экспортод хувиар	-0.9	-3.8	-32.8	-17.0	-12.1	-42.3

Эдгээр тоо баримтаас үндэслээд дараах дүгнэлт хийж болох байна. Үүнд:

1. 2008 оныг дуустал Дэлхийн эдийн засгийн байдал манай экспортын орлогод мэдэгдэхүйц нөлөөлөөгүй байна. 2008 оны эхний хагаст экспортын орлого 2007 оны мөн үеийнхээс 52.6% өсч байсан бол сүүлийн хагаст 20.0% өсчээ.
2. 2006 он, 2007 оны эхний хагаст тэнцвэртэй байсан гадаад худалдааны баланс 2007 оны сүүлийн хагасаас огцом унажээ. 2007 оны сүүлийн хагаст импортын хэмжээ оны эхний хагасаас 43.8% өсч, 2008 оны

эхний хагаст 95.2% өсчээ. Энэ нь “Их бүтээн байгуулалтын бодлого”-оос үүдэлтэй импортын дон болсныг харуулж байна. Гадаад худалдааны балансын алдагдал 2006 оны эхний хагастай харьцуулбал 2007 онд 5.7 дахин, 2008 онд 75 дахин, 2009 онд 23 дахин их болжээ.

3. Дэлхийн эдийн засгийн хямрал манай орны хувьд 2009 оноос мэдэгдэхүйц нөлөөлжээ. Энэ нь суурь металлын олон улсын зах зээлийн үнэ хүчтэй хэлбэлзэж, эрэлт буурсантай холбоотойгоор илэрчээ (Хүснэгт 18).

Хүснэгт 18

	1 тн-ын үнэ /ам.дол			2007 он = 100	
	2007 он	2008 он	2009 он	2008 он	2009 он
1	2	3	4	5	6
Алт (1 тн = сая \$)	20.25	27.1	27.3	133.8	134.8
Зэсийн баяжмал	1235.1	1433.5	654.2	107.3	49.00
Цайрын баяжмал	1326.1	1128.5	676.3	85.1	51.0

Алтны борлуулалтын үнэ буурсангүй. Харин зэс, цайрын баяжмалын үнэ 2 дахин буурчээ. Энэ нь экспортын орлого буурахад нөлөөлсөн нь дамжиггүй.

Бэрхшээл учруулсан мэт ойлголт түгээмэл байдаг. Энэ ойлголтод ч болгоомжтой хандах үндэслэл байна. Автын бензин, дизелийн түлшний үнийн 2007 – 2009 оны динамикийг хүснэгт 19-д үзүүлэв.

4. 2008 онд газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ огцом өссөн нь манай эдийн засагт их

Хүснэгт 19

	1 тн-ын үнэ /ам.дол			2007 он = 100	
	2007 он	2008 он	2009 он	2008 он	2009 он
1	2	3	4	5	6
1. Автын бензин	690.7	988.3	504.8	143.1	73.1
2. Дизелийн түлш	698.2	1092.5	592.8	156.4	84.7

Шатахууны үнэ 2008 онд өмнөх оноос 43.1-56.4% өссөн ч 2009 оны эхний хагаст 2007 оныхоос 15.3 – 26.9% хямд, 2008 оныхоос 45.7 – 49.0% хямд байна. Манай экспортын гол нэрийн барааны үнэ огцом өсч байсан 2008 онд шатахууны үнэ өссөн нь хямралд хүргэх шалтгаан биш бөгөөд

зөвхөн дотоод зохицуулалтын л асуудал юм. 2009 онд манай экспортын зарим гол барааны үнэ буурсан ч шатахууны үнэ бас л хэм тэнцүү буурчээ. Энэ нь ч бас ужгирч байгаа хямралын шалтгаан биш билээ. 2009 оны эхний хагасыг 2008 оны мөн үетэй зэрэгцүүлбэл, манай эдийн засаг

зэсийн үнийн уналтаас 225.9 сая доллар алдаж, шатахууны үнийн бууралтаас 154.5 сая доллар олжээ. Зөрүү 71.4 сая доллар нь экспортын орлогын 9.4% болж байгаа нь хэвийн тохиолдолд байж болох хэлбэлзэл юм.

5. Шатахууны үнэ огцом өссөн 2008 онд манай орон бензиний импортыг 6%, дизелийн түлшийг 10.8% нэмээд, үнэ нь хямдарсан энэ жил бензинийг 23%, дизелийн түлшийг 14.2% болгож бага импортлосон нь өнгөрсөн жил нефтийн үнийн өсөлтийн оргил үед нөөц нэмэгдүүлэх төрийн бодлого хэрэгжүүлсэнтэй холбоотой.

Үүнээс үзвэл, 2009 оны эхний хагасын динамик жилийн турш үргэлжилбэл хөдөө аж ахуй (мал аж ахуй, газар тариалан)-аас бусад бодит эдийн засгийн салбар 7.2 – 38.2%-ийн бууралтад орох замаар явж байна. Экспорт 30% буурчээ. Импортын бууралтаар энэхүү валютын нөөцийн бууралтыг нөхөж болох боловч тэр нь эргээд дотоод зах зээлийн явцуурал, үйлдвэрлэл, хэрэглээний аль алины нь уналттай холбоотой байх болно.

Үүний зэрэгцээ банк санхүүгийн хүрээний байдал улирал тутам доройтож байгаа нь эдийн засгийн сэргэлт эхлэх боломжид улам бэрхшээл учруулж байна.

2009 оны эхний 7 сарын байдлаар экспортын орлого өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 539.9 сая.ам доллараар буурсны 85.7% буюу 462.5 сая.ам долларыг үнийн бууралт, 14.3% буюу 77.4 сая ам долларыг барааны үйлдвэрлэлийн бууралт эзэлж байна. Үнэ нь унасан барааны дотор зэсийн баяжмал онцгой байр эзэлж байгаа бөгөөд эхний 7 сард 335.3 мян.тн баяжмалыг тонн тутамд 683 ам доллараар борлуулж, өнгөрсөн жилийнхээс 291.7 сая доллараар бага орлого олсон.

Дээрх хугацаанд тунгаасан зэс, зэсийн хайлшийг тонн тутамд 4020 долларын дундаж үнээр борлуулж байжээ. Зэсийн үнэ сүүлийн хагас жилд 6000 доллар хүртэл өсөхөөр бодоход ч дээрх алдагдлын 2/3-ийг нөхөж чадахгүй юм. Молибден, цайр, газрын тосны үнийн уналтаас үүссэн 150 сая долларын хохирол нөхөгдөхгүй нь магад биз.

3.6. Үйлдвэрлэлийн зарим динамик

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2006 оноос хойш жилд 8.6 – 9.9%-иар өсч байсан. ҮСХ-ны тооцоогоор 2009 онд 1.3% буурах төлөвтэй ажээ. ҮСХ ийм тооцоог 2005 оны үл хөдлөх үнээр хийдэг. Хэрэв экспортын барааны үнээс алдсан валютын орлогын бууралтыг нэмж тооцвол 2009 оны ДНБ

өнгөрсөн оны бодит хэмжээнээс 11.1 – 13.0% буурах төлөвтэй.

2009 оны эхний хагас жилийн байдлаар үйлдвэрлэлийн гол салбарууд дараах динамиктай байна (Хүснэгт 20).

Хүснэгт 20

	Эхний хагас жил			2007 оны II = 100		2009 2008
	2007 он	2008 он	2009 он	2008 он	2009 он	
1	2	3	4	5	6	7
1 Аж үйлдвэрийн бүтээг-дэхүүн (2005 оны зэр.үнэ)- тб.т	770.5	799.9	742.9	103.8	96.4	92.8
2 Барилга угсралт (оны үнээр)- тб.т	68.4	108.2	66.9	158.1	97.8	61.8
3 Бойжуулсан төл (сая. толгой)	11.9	12.1	13.6	101.7	114.3	112.4
4 Тариалсан талбай (мян.га)	195.8	190.3	280.3	97.2	143.1	147.3
5 Бөөний худалдаа (сая.төг)	165.5	319.2	273.1	192.9	165.5	85.5
6 Жижиглэнгийн худалдаа (сая.төг)	156.4	254.9	181.1	162.9	115.7	71.2
7 Экспорт (сая.долл)	836.2	1276.3	892.8	152.6	106.8	70.0

4. 2009 ОНЫ III УЛИРЛЫН ТӨРХ

Манай ҮХШХ зэрэг институтүүд 2009 оны 7-р сараас эдийн засгийн хямрал шувтарч сэргэлт эхэлснийг оношилжээ.

ҮСХ-оос гаргасан 2009 оны III улирлын мэдээнээс үзвэл, өнгөрсөн онтой харьцуулахад дараах динамик ажиглагдаж байна (Хүснэгт 21).

Хүснэгт 21

Үзүүлэлтүүд	Өөрчлөлт хувь (%)	
	2009 I – III 2008 I – III	2009 III 2008 III
1	2	3
1. Хэрэглээний үнийн индекс	-0.1	-2.7
2. Төсвийн цалин хөлс	+9.4	+4.1
3. Тэтгэвэр, тэтгэмж	+2.1	2.1
4. АҮ-ийн хөдөлмөрийн бүтээмж	-5.5	-9.7
5. Улсын төсвийн орлого	-17.8	-13.8
6. Улсын төсвийн зарлага	+2.6	-1.4
Үүнээс: урсгал зардал	+2.8	+3.3
7. Нийт мөнгө	+5.1	+5.1
8. Нийт зээл	-3.2	-54.3
Үүнээс: чанаргүй зээл	5.29 дахин	47.5 дахин
9. Экспорт	-33.9	-22.2
10. Импорт	-38.8	-19.0
11. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн (2005 оны үнээр)	-10.6	-16.3
12. Барилга угсралтын ажил	-31.5	-24.6
13. Хурааж авсан үр тариа	+59.9	+59.9
14. Хураасан хүнсний ногоо	+28.6	+28.6

Эдгээр тоо баримтаас үзвэл, манай эдийн засагт хямрал илааршиж, сэргэлтийн үе эхэллээ гэж дүгнэх нь эртэдсэн хэрэг төдийгүй харин ч ужиг хүнд бэрхшээл тохиолдох эрсдэл улам нэмэгдэж байна гэж үзэх үндэслэл бодитой байна. Учир нь:

1. Газар тариалангаас бусад салбарт үйлдвэрлэл өсөөгүй, харин ч өмнөх жилээс бууралттай байна. Аж үйлдвэрийн үйлдвэрлэл оны эхний 9 сарын дүнгээр өмнөх оныхоос 10.6% бууралттай байсан бол зөвхөн 3-р улирлаар жишвэл 16.3%-ийн бууралттай байна. Аж үйлдвэрт хөдөлмөрийн бүтээмж 9 сарын дүнгээр 5.5% доошилсон бол 3-р улирлаар жишихэд 9.7% доошилжээ.
2. Экспорт, импортын хэмжээ өнгөрсөн оны 9 сарын түвшнээс 33.9-38.8% бууралттай байна.
3. Улсын төсвийн орлого 9 сарын дүнгээр 17.8%, 3-р улирлын багцаар 13.8%-ийн бууралттай байна. Гэтэл төсвийн урсгал зардал 9 сараар 2.8%, 3-р улирлаар 3.3% өсчээ.
4. Нийт мөнгөний хэмжээ 5.1%, үүнээс банкны гадуурх мөнгө 0.7% өсчээ. Дээрх хугацаанд төсвийн цалин хөлс 9.4%, тэтгэвэр тэтгэмж 2.1% өссөнийг харгалзвал мөнгөний нийлүүлэлтийн дээрх тоо баримт нь хэрэглээний зах зээлийн хямрал үргэлжилж байгаагийн илрэл юм.
5. Банкны зээлийн эргэлт илт удааширч энэ хүрээнд байдал ихэд хүндэрчээ.

Энэ оны эхний 3 улирлыг өнгөрсөн жилийнхтэй харьцуулбал зээлийн үлдэгдэл 4.2% буурсны дотор 3-р улиралд зээлийн үлдэгдлийн өсөлт 54.3% буурчээ. Харин чанаргүй зээлийн үлдэгдэл оны эхний 9 сарын дүнгээр 5.29 дахин өссөний дотор 3-р улиралд үүссэн чанаргүй зээл 47.5 дахин өсчээ. Банкны салбарт хуримтлагдаж байгаа асуудлыг дараах хүснэгт 22-оос харж болох юм.

Хүснэгт 22

	2008 он		2009 он		2009 он / 2008 он - %	
	6 сар	9 сар	6 сар	9 сар	6 сар	9 сар
	2	3	4	5	6	7
1. Банкны нийт актив (пассив)-тб.т.	3281.3	3427.4	3603.7	3814.7	109.8	111.3
Үүнээс:						
- Төв банкны үнэт цаас	63.3	41.1	143.9	356.7	227.3	867.9
- Банкны нөөц	198.4	229.6	466.0	376.6	235.3	164.0
- Өөрийн хөрөнгө	426.6	479.8	323.4	249.8	75.8	52.1
2. Нийт актив (пассив)=100	100.0	100.0	100.0	100.0	-	-
- Төв банкны үнэт цаас	0.19	1.2	4.0	9.3	-	-
- Банкны нөөц	6.0	6.7	12.9	9.8	-	-
- Өөрийн хөрөнгө	13.0	14.0	8.98	6.5	-	-
3. Нийт зээлийн өр – тб.т	2559.4	2716.8	2558.9	2630.9	99.98	96.8
- Хугацаа хэтэрсэн	54.6	54.8	152.1	198.2	278.5	361.7
- Чанаргүй	73.1	75.1	297.9	397.7	407.5	529.6
4. Нийт зээл = 100	100.0	100.0	100.0	100.0	-	-
Үүнээс						
- Хугацаа хэтэрсэн	2.1	2.0	5.9	7.5	-	-
- Чанаргүй	2.8	2.8	11.6	15.1	-	-

Эндээс үзвэл, банкны салбарт нүүрлэж буй хямрал дараах шинжээр илэрч байна:

1. Банкны нийт пассивт эзлэх өөрийн хөрөнгийн хувь 2008 оны III улиралд 14% байсан бол 2009 оны III улиралд 6.5 болж буураад мөнгөний дүн нь мөн хугацаанд 47.1%-иар багасчээ. Банкны байдал тогтворгүй болж байна.

2. Банкны нийт активт Төв банкны үнэт цаас 2008 оны 3-р улиралд 1.2%-ийг эзэлж байсан бол 2009 оны 3-р улиралд 9.8% болж өсчээ. Арилжааны банкуудын бие даасан байдал, үйл ажиллганы чөлөөт боломж хумигдаж байна.

3. Банкны нөөц жилийн хугацаанд 2.3 дахин өсч, нийт активын дүнд эзлэх хувь нь 2.2 дахин өсчээ. Энэ нь мөнгөний эргэлт

суларч, эрсдэлийн хүлээлт бий болж байгааг илтгэнэ.

4. Нийт зээлийн хэмжээ 2008 оны III улиралтай харьцуулбал 3.2% буурч, харин хугацаа хэтэрсэн зээл 3.6 дахин, чанаргүй зээл 5.3 дахин өсчээ. 2008 оны III улирлын эцэст хугацаа хэтэрсэн зээл нийт зээлийн 2.0%-ийг эзэлж байсан бол одоо 7.5% болж, чанаргүй зээл 2.8% байсан бол 15.1% болж, найдваргүй зээл нийт зээлийн 22.6%-д

хүрчээ. Энэ оны III улирлыг II улиралтай харьцуулбал, хугацаа хэтэрсэн зээл 30.3%, чанаргүй зээл 33.5% өсчээ.

Энэ бүхнийг нэгтгэн дүгнэвэл, банкны сектор нэн хурц хямралын ирмэгт тулаад байгаа бөгөөд төрийн маш огцом хүчтэй дэмжлэггүйгээр үүнээс зайлж чадахгүй. Банкны салбарын сүйрэл нь эдийн засгийн төдийгүй нийгмийн хүчтэй хямралд оруулж болохыг төр анхаарах цаг болжээ.

5. СҮҮЛИЙН ГУРВАН ЖИЛИЙН ЗАМНАЛЫН ДҮГНЭЛТ, СУРГАМЖ

Монгол орон түүхэндээ анх удаа зах зээлийн эдийн засгийн тогтолцооны хямралтай нүүр тулж, Дэлхийн санхүүгийн хямралын давалгаанд хөвж үзлээ. Хямралд орсон зам мөр, гарах арга, хямралын үр дагаварын талаар улс төрчид, эдийн засагчид, бизнесменүүдийн санал дүгнэлт нэгдээгүй байна.

Өмнө өгүүлсэн манай эдийн засгийн тоо баримтын судалгаанаас үзвэл, одоо туулж буй эдийн засгийн хямрал угсраа хоёр хямралын нийлбэр мөн бөгөөд давхар цохилтын агуулгатай ажээ. Тухайлбал:

1. 2007 оны дунд үеэс манай төрийн арчаагүй, алдаатай бодлогоос улбаалсан дотоодын “гар үйлдвэр”-ийн хямрал эхэлж 2008

оны дунд үед оргилдоо хүрчээ. Энэ нь 2007 оны дунд үеэс инфляци өсч, макро – эдийн засгийн тэнцвэрүүд алдагдан, 2008 оноос мөнгө, зээлийн бодлого будилж эхэлснээр нотлогдоно. Энэ үед төрөөс “их бүтээн байгуулалт” зарлаж, хэт хавтгайрсан “нялуун” нийгмийн бодлого явуулж, Олон улсын зах зээлийн мөчлөгөөр тохиосон таатай нөхцлийг хор болгож ашиглажээ.

2. Дотоодын учир шалтгаантай “гар үйлдвэр”-ийн хямрал оргилдоо хүрч инфляци 34%-иас хэтэрч, гадаад худалдааны алдагдал 23.9%, төсвийн тэнцэл алдагдах мөчид Дэлхийн санхүү - эдийн засгийн хямрал нэрмэж цохиод муужралд оруулжээ.

Эдүгээ манай орны эдийн засаг дээрх хос хямрал банкны салбарыг сүйрүүлэх эсэхийг шийдэх мөчид тулаад байна.

Хямрал эхэлснээс хойш жил гаруй хугацаанд буюу 2008 оны III улирал дуустал төрийн институтууд эдийн засгийн бодлогыг эрүүлжүүлэх ямар ч арга хэмжээ аваагүйгээр үл барам, үр ашиггүй хөрөнгө оруулалтыг дэмжиж төгрөгийн ханшийг чангаруулж, мандал бадралын уриа дэвшүүлсээр байлаа. Дэлхийн санхүү - эдийн засгийн хямралын цохилт нэгэнт эхэлсэн 2008 оны IV улиралд ч төр нүсэр алдагдалтай төсөв баталж, харин ч хямралаас хожих боломжийн тухай яриа гарсаар байлаа. 2008 оны эцсийн улиралд байдал найдваргүй болсны дараа Засгийн газар, Улсын Их Хурлаас иргэдийн хадгаламжийг төрөөс баталгаажуулах тухай (үнэндээ ямар ч баталгаагүй хэвээр үлдээх) шийдвэр гаргаж, Монгол Банк бодлогын хүүгээ эрс нэмэхээс өөр арга хэмжээ авсангүй.

2009 оны эхэнд Засгийн газраас хямралыг гэтлэх төлөвлөгөөг УИХ-д оруулан батлуулав. Уг төлөвлөгөөний гол цөм нь гадаадаас 1500 тб.т-тэй тэнцэх ам.доллар зээлж эдийн засгийг тэтгэхэд чиглэж байв. Монгол орны эдийн засаг хэдий овор багатай, нээлттэй чанартай боловч тогтолцооны нэгдмэл, цогц шүтэлцээтэйг төр засаг ойлгосонгүй. Одоо тэр 1500 сая.доллар ч байхгүй, ОУВС, Хандивлагчдын армаг тармаг зээлээр өдөр хоног аргацаахад дулдуйдаж байна. Сүүлийн

саруудад илэрч буй хэрэглээний үнийн бууралтыг хямралаас гарч буйн баримт болгон сурталчилж байгаа боловч тэр нь хямрал даамжирч “дефляц”-ийн үзэгдэл илэрч байна гэвэл үнэнд ойртоно. Энэ оны III улиралд өмнөх оны мөн үеэс жижиглэнгийн худалдаа 28.8%, бөөний худалдаа 30%, импорт 38.8% буураад байхад үнийн бууралт нь дефляцаас өөр юуг илэрхийлэх билээ.

Дэлхийн санхүү - эдийн засгийн хямрал манай орны эдийн засагт хамгийн хурц нөлөөлсөн чиглэл нь ашигт малтмалын Олон улсын зах зээлийн хэрэгцээ буурч, үнэ унаснаар илэрчээ. Энэ бол уул уурхайн чиглэл баримжаалсан түүхий эдийн дагуул эдийн засгийн тавилан юм. Өөрөөр хэлбэл, манай эдийн засаг “Голланд өвчин”-д аль хэдийн нэрвэгдсэний үр дагавар энэ буюу.

Улс орны ирээдүй хийгээд ард иргэдийн амьдралд асар хүнд уршиг тарьж буй энэ удаагийн эдийн засгийн хямрал Монголд төрийн бодлогод хатуу сургамж үлдээж байна. Үүнд:

1. Монгол төр (УИХ, Засгийн газар)-өөс явуулах эдийн засгийн бодлогын үндэслэл, чиг хараа, арга барилыг орчин цагийн дэлхийн ухаарал, уур амьсгалын түвшинд хүргэхгүйгээр манай улсын эдийн засаг эрүүл оршин тогтнож чадахгүй. 2000 оноос хойш улс төрийн намуудын төрийн эрх мэдлийн төлөө тэмцэлд үндэснийхээ эдийн

засгийн даац чадвараас хэтэрсэн амлалт цухалзах болсоор 2008 оны сонгуульд эдийн засгийг улс төрийн барьцаа, золиос болгох түвшинд хүрсэн. 2007 оны дунд үеэс төрийн дээд байгууллагууд 2008 оны УИХ, орон нутгийн сонгуульд чиглэсэн популист бодлогод автаж, тэр үед эхэлсэн зах зээлийн эерэг мөчлөгийг тогтвортой хандлага мөн гэсэн төөрөгдөлд автсанаар “гар үйлдвэрийн” хямрал эхэлсэн.

Эдийн засгийн хямрал гүнзгийрч, Дэлхийн эдийн засгийн хямралтай давхцан резонансод орсон нөхцөлд одоогийн УИХ, Засгийн газар эрүүл саруул бодлого явуулах өчүүхэн ч чадваргүйгээ нотоллоо. Банк, санхүү, мөнгөний бодлого дампууралд орж, одоо татвар төлөгчдийн төлсөн татвар, хойч үедээ үүрүүлж гадаадаас авсан зээлээр наад зах нь 500 тб.төгрөгийн зарцуулахаас нааш сэхэхгүй болжээ.

Төрийн институтын түвшин бүрд түүний чиг үүрэгт тохирсон мэргэжлийн мэргэшсэн хүмүүс ажиллах ёстой. Гэтэл одоогийн УИХ, Засгийн газраас эхлээд төлөвлөж хэрэгжүүлж байгаа эдийн засгийн бодлого нь “ганзагын наймаачдын ойлголт”-ын түвшинд явж иржээ. Үүнийг өөрчлөх шаардлагатай.

2. Одоогийн манай төрийн тогтолцоо оновчтой, үнэдслэлтэй, хяналттай эдийн засгийн бодлого явуулах боломжгүй

болгож байна. Сонгуулийн явцад хөрөнгө чинээний хэмжээгээр өрсөлдөн, аманд багтах хэмжээгээр ам өчиг өгч УИХ-д сонгогдсон, төрийн бодлогын төсөөлөлгүй гишүүд төрийн сайдын алба хаших болсон 2000 оноос хойш төрийн бодлого бизнесийн сонирхолтой илэрхий хутгалдаж, мэргэжлийн бус сайдын “сайн дурын уран сайханчийн тоглолт” болж хувирчээ. 2007 оноос зарлаж 2008 онд үргэлжлүүлсэн “их бүтээн байгуулалт”-ын бодлого ч ийм байсан. Үүний балгаар улс орны эдийн засгийг үйлчилж буй бүх мөнгөний 1/3-ийг дуусаагүй барилгад түгжээд байгаа билээ. 2009 онд хилийн чанадаас мөнгө зээл гуйх доншуучлал ч ийм байсан.

Одоог хүртэл Монгол Банкнаас явуулсан мөнгө, зээлийн бодлого ч ийм байсан. УИХ, Засгийн газрын хариуцлагын заагийг тодотгох цаг болжээ.

3. Улс төр, бизнесийн сүлбээнд түшиглэсэн төрийн бодлого дампууралд хүргэдэг нь энэ хямралаар илэрч байна. Энэ сүлбээ банкуудад тулгарч буй бэрхшээлийн нэг гол үндэс болж байгаа нь өдөр сараар улам тод болж байна. Түүнчлэн хөдөө нутагт мал, түүхий эдийн үнэ огцом унаж малчдын амьдрал эрс хүндэрч байхад энэ оны зун хот суурин газар махны үнэ огцом өссөн нь энэ сүлбээний хор уршгийн нэг илрэл болов. Зах зээлийн эдийн засгийн суурь үнэ бүрдүүлдэг түлш, шатахуун, эрчим хүчний

үнэ жил дараалан нэмэгдэж, эдийн засагт хүнд дарамт болж ирсэн ч төр засаг үүнийг гэтлэх талаар оновчтой ямар ч арга хэмжээ авсангүй. Уул уурхайн цөөнгүй объектууд олон жил төрийн хараа хяналтаас гадна үйл ажиллагаа явуулж эдийн засаг, байгаль орчинд нөхөгдөшгүй хохирол учруулсаар байгааг нийтээр мэднэ.

Улс төр – бизнесийн сүлбээнд түшиглэсэн төрийн бодлого хөрөнгө мөнгө хэмнэх, үр ашигтай зарцуулах чадваргүй байдгийг өнгөрсөн 3 жилийн улсын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл тод харуулав.

Төсвийн зардлын төрөл зүйл бүрийн ард тодорхой бизнесийн бүлгийн сонирхол байж, улс орны эдийн засаг төсвийн ам тоссон “хуваарилалтын эдийн засаг” болсныг мэргэжлийн хүмүүс олон жилийн өмнөөс анхааруулсаар ирсэн ч төр сонссонгүй. Улс орны эдийн засаг хямарч түүхийн хүнд сорилтод орж байгаа энэ үед төрийн бодлогын мэдрэмжийг дээшлүүлэх шаардлага нэн хурц болжээ.

4. Түүхий эдийн баримжаатай, өрөөсгөл бүтэцтэй эдийн засаг дэлхий нийтийг хамарсан хямрал байтугай цөөн төрлийн түүхий эдийн зах зээлийн нөхцөл (конъюнктур)-ийн барьцаанд байдгийн хатуу сургамж хямралын тамгатай үлдлээ. Түүхий эдийн олборлолт, экспортод гадаад

дотоодын хөрөнгө оруулалтыг ямар ч үнээр болов татаж экстенсив эдийн засгийн өсөлтийн бодлого цаашид явуулах нь эдийн засгийг улам хэврэг эмзэг болгох нь тодорхой байна.

5. Төр засаг эдийн засгийн хямралын янз бүрийн чиглэлийг сөрж гэтлэх бодлогын хувилбар, хөрөнгө, хүчний нөөцтэй байхын хатуу сургамж үлдлээ. Экспортын түүхий эдийн 2006-2008 оны өсөлтөөс олсон орлогыг ухаалгаар хуримтлуулж, хэрэглэсэн бол энэ удаагийн хямралыг үлэмж хөнгөн давах бололцоо байсан. Гэтэл чухамхүү төрийн дээд институтүүдийн санаачлагаар ухаалаг бусаар үрэн таран хийсэн нь өөрөө хямралыг сэдэж эхлүүлсэн. Ийм байдал давтагдах боломжийг хаах цаг болжээ.
6. Төрийн макро – эдийн засаг, санхүү, мөнгө, зээлийн бодлогын цогц бус, уялдаа холбоогүй байдал нь хямрал нүүрлэсэн үед түүний үйлчлэх хүчийг улам нэмж, хямралыг ужигруулж байна. Чухамхүү ийм задгай байдал энэ удаагийн хямралын эхийг тавьж, сүүлийг хүндрүүлж байна. Уг нь төрийн бодлогын ийм уялдааг УИХ-ын хүрээнд хангах нь зүйн хэрэг боловч энэ шаардлагад нийцсэн бүтэцгүй, Байнгын хороод нь үйл ажиллагаагаа уялдуулж зангидах чадваргүй байгаа нь 2008-2009 оны ээлжит чуулганы явцад тодорхой харагдлаа.

УИХ төрийн дээд байгууллагын түвшинд бодлого томъёолох, хуульчлахаас илүү улс төрийн намуудын наймааны талбар болж, түүний үр дүнг нийгэмд тулгаж байгаа нь энэ удаагийн хямралтай холбоотой бүх асуудлыг хэлэлцэх явцад илэрлээ.

Монголын төр нэгдмэл эдийн засгийн бодлого хэрэгжүүлэх цаг болжээ.

7. Өргөн хүрээтэй эдийн засгийн хямралын үед банкуудын тэсвэрлэж даах чадварыг дээшлүүлж, эрүүл үйл ажиллагааны нөхцлийг тэтгэх нь төрийн бодлогын үгүйлэгдэж буй зангилаа болж байна.

Одоогийн хямрал эхэлмэгц Төрөөс иргэдийн хадгаламжийг баталгаажуулна хэмээн амалсан нь иргэдийг тайвшруулсан ч уг чанартаа алдаатай бөгөөд хоосон амлалт юм. Энэ нь банкуудыг буруу алхам хийхэд хүргэж болохоос гадна, төр нь татвар төлөгчдийн мөнгөөр хариуцлагагүй ажиллагааны алдагдлыг нөхөж, банк дампууруулсан зээлдэгчид завших боломж олгож байна.

Банкны дархлаа нь хадгаламжийн даатгалтай холбоотой хэрэгжинэ.

Банкуудын гүйлгээнд аюулгүй байдлын талаас төрийн хатуу хяналт хэрэгтэйг ойлгох цаг болжээ.

8. Одоогийн хямралд хамгийн хүчтэй нэрвэгдсэн нийгмийн бүлэг бол малчид юм. Тэдний орлого буурч, хэрэглээний үнэ өсөв. Гэтэл энэ үед төрөөс малчдын талаар явуулсан бодлого нь тэдний чинээлэг хэсгийг дэмжих төдий байв.

Түүгээр ч барахгүй зөвхөн ямааны аж ахуйг дэмжсэнээр мал аж ахуйг улам эмзэг төлөв рүү хөтөллөө. Малчдын амьжиргаа, мал аж ахуйн тогтвортой байдлыг зах зээлийн хэлбэлзэл, цаг уурын гэнэтийн өөрчлөлтөөс хамгаалах байнгын ажиллагаатай нэгдмэл тогтолцоо үгүйлэгдэж байна. Энэ асуудлыг шийдэхгүйгээр улс орны эдийн засаг тогтворжиж чадахгүй.

9. Энэ удаагийн манай орны эдийн засгийн хямралын нэг гол үндэс нь олон улсын зах зээл дээрх нефтийн үнийн хэлбэлзэл байлаа. Өөрийгөө шатахуунаар хангах төрийн бодлого үгүйлэгдэж байна. Одоогийн нефть импортлогчид ийм бодлогыг дэмжихгүй бөгөөд хэрэгжүүлж чадахгүй.

Энэ мэт цөөхөн зүйл сургамж хямралын бүх хүрээг хамрахгүй. Гэвч эхний алхамд тустай байна гэдэгт итгэж байна.

